



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/88

Алтрага

Хүлээж авах хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Эмт багийн Дэлгэрмөрөн гол дагуух 4 цэгт зам даваа засах" ажлыг хүлээж авах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Баттулга
(Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч)
Гишүүн: Д.Батсайхан
(Газрын даамал)
Нарийн бичгийн дарга: Э.Эрдэнэбилэг
(Эмт 1 дүгээр багийн Засаг дарга)

2.2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Эмт багийн Дэлгэрмөрөн гол дагуух 4 цэгт зам даваа засах" ажлыг хууль журмын хүрээнд хүлээж авахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Баттулга)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010202